

ФИЛАНТРОПИ НИЙГМИЙГ ӨӨРЧИЛНӨ



Монголын Эмэгтэйчүүдийн Сан /МОНЭС/

**ФИЛАНТРОПИ
НИЙГМИЙГ
ӨӨРЧИЛНӨ**

*Сайн үйлсийн төлөө
хувь нэмэр оруулах нь
нийгэмд хувь нэмэр
оруулж байна гэсэн үг.*

Улаанбаатар 2007

Хоёр дахь хэвлэл

Монголын Эмэгтэйчүүдийн Сан /МОНЭС/

Боловсруулсан: Н.Чинчулуун

Орчуулсан: Б.Нандинчимэг

Хянасан: П.Соёлдэлгэр

Эх бэлтгэл: Л.Мөнхтөр (mouji design)

Нэгдүгээр бүлэг

Филантропи гэж юу вэ?

1. Ойлголт 7
2. Та нийгмийн ямар асуудалд санаа зовж явдаг вэ? 9
3. Сайн дурын үйл ажиллагаа ба бие биенээсээ суралцах нь 12

Хоёрдугаар бүлэг

Филантропийн хөгжил

1. Түүх өгүүлж байна 17
2. Орчин үеийн филантропи 21

Гуравдугаар бүлэг

Монголчуудын филантропи сэтгэлгээ

25

Дөрөвдүгээр бүлэг

Та филантропч байж чадна

1. Филантропчид ямар учраас хандив өргөдөг вэ? 33
2. Филантропч болохын ач холбогдол 35
3. Жинхэнэ филантропч 39
4. Хүүхэд залуучуудад бусдын төлөө гэх сэтгэлийг төрүүлж, хандив өргүүлж сургах нь 40
5. Хандивлагчийн эрх 42


Тавдугаар бүлэг

Монголын Эмэгтэйчүүдийн Сан филантропи үйл хэргийг хөгжүүлж байна

43

Нэгдүгээр бүлэг

Хүний тус багадахгүй.



**ФИЛАНТРОПИ
ГЭЖ ЮУ ВЭ?**

Нэг. Ойлголт

Филантропи гэдэг нь грек хэлнээс гаралтай. “Фила” гэж “хайр”, “тропи” гэдэг нь “хүн” гэсэн үг. Өөрөөр хэлвэл “хүнийг хайрлах хайр” гэсэн үг.

Орчин үед филантропи гэсэн үг нь “бусдыг хайрлаж тэтгэн туслахын тулд хандив өргөх” гэсэн утгыг илэрхийлдэг. Өөрөөр хэлвэл филантропи нь бэрхшээлтэй байгаа хүмүүсийн асуудлыг шийдэхийн тулд мөнгө болон эд зүйл бэлэглэх гэсэн ухагдахуун дээр тогтдог.

Филантропч гэдэг нь “бусдын сайн сайхны төлөө цаг зав, оюун ухаан, хөдөлмөр, хөрөнгө мөнгөө хандивлагч”-ийг хэлдэг. Филантропч буюу нийгмийн сайн сайхны төлөө хандив өргөдөг хүний хувьд ийм зүйл хийх ёстой, төдий хэмжээний мөнгө хөрөнгө хандивлах ёстой гэсэн хэмжээс байдаггүй. Харин санаа зовж явдаг зүйлийнхээ төлөө жил бүхэн мөнгө, хөрөнгө хандивлаж байгаа бол таны филантропи сэтгэлгээ улам

гүнзгийрч байна гэсэн үг юм. Филантропи бол таны хүсэл мөрөөдлийн илэрхийлэл, үйл ажиллагаа, үр дүн юм. Үүнд 2 жишээ авч үзье.

Хатагтай Лорен хэлэхдээ:

“Би хүмүүнлэгийн төлөө ажилладаг нэг байгууллага дээр байнга очиж ажилд нь тусалдаг. Бичиг баримтыг нь эмхлэн цэгцлэх, мэдээ, мэдээлэл түгээх гээд олон ажил тэдэнд байдаг. Би очих бүрийдээ шинийг мэдэж, шинэ найз нөхөдтэй болж аз жаргалтай явдаг. Энэ нь надад цагийг уйтгартай өнгөрөөснөөс хамаагүй дээр шүү дээ.”

АНУ-ын Орегон мужийн нэгэн хандивлагч ярихдаа: *“Би ном, хөгжим, хоолонд маш их дуртай. Тийм болохоор зарим ядуу залуучууд, хүүхдүүдэд ном, хөгжим, СД, тоглоом бэлэглэж мөхөөлдөс авч өгдөг. Хэдийгээр миний бэлэг тэдний амьдралыг өөрчилж чадахгүй ч тэдний зүрх сэтгэл баяр баясгалангаар дүүрч, аз жаргалаар*

дүүрэн инээмсэглэж амьдралыг сайн сайхнаар харж өөдрөг итгэлтэй болгодог гэдэгт итгэдэг” гэжээ.

Тэгэхээр өглөг, хандив гэдэг багададгүй. Бусдаас бэлэг авч баярлаж байсан хүн цаашдаа бусдыг бас баярлуулдаг хүн болох үүд хаалга нээгддэг байна.

Хоёр. Та нийгмийн ямар асуудалд санаа зовж явдаг вэ?

Хандивлагч Харри Барлов хэлэхдээ: *“Хандив өгөх явдал намайг “би өөрөө хэн бэ? би юу хүсэж байна вэ?” гэдгийг мэдрүүлж ойлгоход тусалдаг. Би энэ дэлхий ертөнц дээрхи олон сая хүн өлсгөлөнгөөр үхэж байгаад санаа зовдог. Тийм учраас би тэдний төлөө хандив өргөдөг. Миний санхүүжүүлсэн төсөл амжилттай хэрэгжсэн эсэхээс үл хамааран хандив өргөх бүртээ би сэтгэл ханамжтай байдаг. Яагаад гэвэл өөрчлөлт гэдэг урт удаан хугацаа шаардагддаг шүү дээ” гэжээ.*

Таны хандивлаж байгаа бүхэн тань хаана илүү бүтээлчээр хэрэгжих боломжтой гэдгийг тодорхойлохын тулд:

1. Та өөрөө нэн тэргүүнд юунд санаа зовж анхаарч байгаагаа мэдэх,
2. Та цаг заваа юунд зориулж чадахаа олж мэдэх,
3. Та өөрийнхөө хөрөнгө мөнгөний тодорхой хувийг юунд оруулвал хувь нэмэр болж чадахаа тодорхойлох явдал юм.

Ер нь ихэнх филантропч хүмүүсийн хувьд мөнгө, хөрөнгө хандивлана гэдэг нь зөвхөн өөрсдийнхөө үнэлэмжийг өсгөхөд илэрхийлэх арга бус хамгийн үнэ цэнэтэй зүйл бол "хүн" юм гэдгийг тодорхойлоход оршино.

Тухайлбал, тэр үнэ цэнэтэй зүйл нь,

1. Нийгэмд шударга ёс, хангалуун амьдралыг бий болгох нь оршин тогтнохын мөн чанар бөгөөд үүний тулд нийгмийн амьдралыг өөрчлөхийн төлөө ажиллах, үүнийг бий болгож байгаа хүмүүст туслах,
2. Зовж зүдэрсэн хувь хүн, хэсэг бүлэг

хүмүүсийн сайн сайхны төлөө ажиллах, өлсөж цангасан хүмүүсийг хооллох, хүүхэд хөгшидийг хамгаалах, эмэгтэйчүүдийн статусыг дээшлүүлэх зэрэг олон асуудлаас сонгож болно.

Филантропич Салли Готтесман хэлэхдээ: *“Үнэнийг хэлэхэд би өөрийн амьдарч буй дэлхий ертөнцөд сэтгэл хангалуун байж чаддаггүй. Мэдээж би амьд байгаадаа, нарны гэрэлд цэцэг тавьсан ширээнд сууж уншиж бичиж, амьсгалж байгаадаа баяртай байдаг. Гэвч энэ дэлхий энх тайван биш байгаад сэтгэл зовж явдаг. Би энэ дэлхийд, амьдарч байгаа орчноо илүү сайхан тохь тухтай байлгах, санаа зовж буй зүйлээ өөрчлөх, бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхийн тулд өөрийн хувь нэмрээ оруулах ёстой гэж үздэг. Би хамтрагчаа олж чадсан бөгөөд өөрийн нийгмийг өөрчлөх хэрэгтэй гэдгийг ухамсарласан учраас өөрийгөө “бодит өөрчлөгч” гэж боддог. Нэг хүнээс эхлэн хэсэг бүлэг хүмүүс ихийг өөрчилж чадна гэдэгт бүү эргэлзээрэй хүмүүсээ” гэжээ.*

Гурав. Сайн дурын үйл ажиллагаа ба бие биенээсээ суралцах нь

Сайн дураараа аливаа үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах явдал бараг бүх соёл иргэншилт нийгмийн салшгүй хэсэг байсаар иржээ.

Энэ үйл хэрэг нь хувь хүн бие биенээ дэмжин амьдрах гүн хүсэл эрмэлзэлтэй байдгийн илэрхийлэл болсон байгалаас заяасан жам ёсны мөн чанар юм.

Сайн дурын үйл ажиллагаа нь бусдын тусын тулд үйлчлэх хүсэл эрмэлзэл бөгөөд эн тэргүүнд бусдын аз жаргал, сайн сайхныг бодох хандлага юм. Сайн дураараа туслана гэдэг нь тухайн хувь хүний сэтгэлийн угаас үзүүлсэн дэмжлэг байдаг ба яаж туслав, ямар үр дүн өгөв гэдэг нь тухайн хүний сэтгэл ханамж хангалуун явахад нөлөөлдөг.

Сайн сайхан өөрчлөлт хийхийн төлөө эрмэлзэж, ажиллаж байгаа төрийн бус нийгмийн төлөө үйл ажиллагаа явуулдаг

байгууллагуудад хүмүүсийн туслалцаа маш их хэрэгтэй байдаг. Бид ийм байгууллагад бусдыг аварч дэмжих үйлст нь цаг зав, ур чадвар, бүтээлч хөдөлмөр шинэ санаагаараа тусламж үзүүлэх нь юунаас ч илүү чухал юм. Хэн нэгэнд туслахын тулд та бид сайн дураараа хэдий хир цаг зав зориулсан билээ?

Цаг үнэтэй гэдгийг бид мэддэг боловч үнэт цагаа юунд зориулсанаа эргэн санахад тийм ч сэтгэл хангалуун байж чаддаггүй. Та цаг заваа юунд зориулсанаа эргээд нэг санаад үзээрэй.

Та дэмжин ажилладаг байгууллагадаа сайн дураараа ажиллаж туслах явдал нь мөнгөний чек бичих, бэлэн мөнгө илгээхтэй нэгэн адил маш үнэ цэнэтэй зүйл юм. Хэрэв та сайн дураараа ажиллаж байгаагүй бол энэ талаар туршлагатай хэн нэгэнтэй яриад үзээрэй. Тэд өөрсдийн амьдрал, ажил төрөл, сайн дурын үйл ажиллагаандаа сэтгэл хангалуун, ирээдүйдээ итгэл дүүрэн

хийж бүтээх асар их урам зоригтой хүмүүс байдаг.

Ашгийн бус үйл ажиллагаанд их бага боловч оролцох нь нийгмийн хөгжилд тодорхой хэмжээний хувь нэмэр оруулж байна гэсэн үг.

Жишээ нь: Монголд 7000 гаруй төрийн бус байгууллага түүний салбар нэгжүүдэд хандивлагчид, сайн дурын ажилтан, удирдлагын хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдсээр байна.

Бид та бүхэнд нийгэм болон бусдад туслах олон төрлийн тусламж, дэмжлэгээс эд хөрөнгө, мөнгө хандивлах тухай илүү тайлбарлан таниулахыг зорьж байна.

Хоёрдугаар бүлэг

“Нэг хүн эргэж хараад хоёр хүнд туславал нийгэм хурдан хөгжинө”.



ФИЛАНТРОПИЙН ХӨГЖИЛ

Нэг. Түүх өгүүлж байна.

Эндрю Корнеги филантропийн эцэг гэж нэрлэдэг. Тэрээр Шотландаас Америкийн Пенселванд ирээд төмрийн үйлдвэрийн эзэн болж өөрийнхөө зүүдэндээ ч төсөөлөөгүй их баян болсон хүн. Тэрээр “эд хөрөнгө өсөх тутам нийгмээс авч байгаа ашгийнхаа заримыг нь нийгэмд буцаан өгөх ёстой. Маш их баян, эд хөрөнгөтэй нас барах нь шившиг” гэсэн сургаалийг гаргажээ. Эндрю Корнеги 1889 оноос эхлэн нийтийн номын санг бий болгосон ба улс даяар явж хотын захиргаануудад нь маш энгийн санал тавьдаг байв. “Би чулуун тоосгон барилга барьж өгье. Та нар номоор дүүргээд хүмүүст уншуул” гэжээ.

Тэрээр 2800 номын сан барьж байгуулсан ч эд хөрөнгө нь дундраагүй, харин ч цаг минутаар өсч байв. Ган төмрийн корпорациа ч худалдав. Үлдсэн 280 сая доллар, 5 хувийн алтан бондтой Корнеги доллар бүрээр дуртайгаа хийх боломжтой байсан. 1910 он гэхэд “Корнеги” корпораци

филантропийн үзэл санааны супер жишээ болж чадсан юм. 1919 онд нас барахдаа эд хөрөнгийнхөө 90 хувийг сайн үйлст зориулж үлдсэн 10 хувийг л хүүхдүүддээ үлдээжээ.

Филантропийн үзэл санааны өрсөлдөгч нь Жон Д. Рокфеллер юм. Тэрээр 1869 онд Standart Oil компанийг байгуулсан. 31 насандаа нефтийн 90 хувийг захирч байв. 1888 онд Рокфеллер анхныхаа энэрэл хайрын бэлгийг өгсөн нь одоогийн Чикакогийн Их сургууль юм. Багш нарын цалин, зардал гээд бүх л зүйлийг өөрөө төлж байсан. Үүнийг “сайхан санаа, сэтгэлийн бизнес” гэдэг байсан ба хувь хүмүүст хандахаасаа илүү бүлэг хүмүүсийн хөгжлийн асуудалд ханддаг байсныг “бөөний филантропи” гэж нэрлэх болжээ. 1901 онд Эрдэм шинжилгээ судалгааны институт байгуулсны нэг нь Рокфеллерийн институт гэсэн нэрээр одоо ч үйл ажиллагаагаа явуулж байна. “Хүн бүр өвчинөө эдгээхийн тулд мөнгө төлдөг. Шинэ эм, эмчилгээг бий болгохыг

мөрөөддөг эрдэмтэдэд мөнгө өгч нээлт хийлгэх нь маш чухал” гэж тэрээр үзэж байв. Үүний үр дүнд нугасны менингит, уушигны үрэвсэл, тархины саажилт зэргийг эмчлэх эмтэй болж чадсан юм.

Рокфеллерийн хүү өвлөн авсан “Рокфеллер сан” одоо 3,6 тэрбум ам долларын хөрөнгөтэй болсон ба сангийн хөрөнгө хумхаа өвчин, халууны өвчин, ДЭМБ-ын судалгаа шинжилгээнд зориулагдахаас гадна шинэ сортын будаа гаргаж дэлхийн хүнсний үйлдвэрлэлд хувьсгал хийсэн юм.

Корнеги, Рокфеллерийн аль нь ч юуг судлах вэ? Юуг нээх вэ? Юунд мөнгөө зориулах вэ? гэдгийг анхааралтай бодож байсан. 20 дугаар зууны эхэн үед ган төмөр, нефть үйлдвэрлэл хамгийн их орлоготой байсан бол одоо гар утас, янз бүрийн жижиг хөдөлгөөнт тоглоомын үйлдвэрлэл маш их мөнгө олж байна. Хөгжлөө дагаад филантропи зохих хэмжээгээр өөрчлөгдөн хөгжсөөр байна.

Билл Гейтс хэмээх нэгэн эрийг бид компьютер үйлдвэрлэлийн хаан гэдгээр сайн мэднэ. 44 насандаа Гейтс 21,8 тэрбум долларын хөрөнгө бүхий “Гейтс ба Мелинда” санг байгуулсан байна. Тус сангийн хөрөнгө нь Холбооны Засгийн газар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын төсөвтэй тэнцэхээр, дэлхийн 25 үндэстний төсөвөөс ч илүү их хөрөнгө мөнгийг сайн үйлст зарцуулж байна. Тус сан “дэлхий ертөнцийн бүх хүн амыг аюулт өвчинөөс сэргийлэх, түүнчлэн салгах” гэсэн даруухан зорилготой. Тэрээр “хүүхдүүд хаана амьдарч байгаагаас үл хамааран вакцин хүртэх ёстой” хэмээн үздэг ба олон улсын вакцины хөтөлбөрийг санхүүжүүлдэг томоохон санхүүжүүлэгчийн нэг юм. Сүүлийн жилүүдэд тус сан саажилтыг арилгах бүхий л боломжийг эрэлхийлсээр байна. Билл Гейтс энэ агуу хүмүүнлэгийн үйлсээрээ Нобелийн энхтайваны шагнал хүртсэн билээ.

Дээр дурьдсан гурван эрийг Америкийн ард түмэн хувийн жаргал, ашиг сонирхолоо бодож байгаагүй “жинхэнэ эрч хүчтэй эрс” хэмээн нэрлэдэг тухай итернэтийн нэгэн сайтад тэмдэглэсэн байна.

Ноён Макл Милкенийг мөн дурьдахгүй өнгөрч болохгүй. Тэр 750 сая долларыг хорт хавдар, ДОХ-ын вирустэй тэмцэхэд зориулаад байна.

Зөвхөн баячууд л өглөг хандивыг бий болгодог, энэ нь тэдний л ажил байна гэвэл огтхон ч тийм биш юм. Энэ тухай дараагийн хэсэгт өгүүлэх болно.

Хоёр. Орчин үеийн филантропи

Одоо дэлхийд хамгийн алдартай Паккард, Форд, Гетти траст хэмээх сангууд болон олон арван санхүүжүүлэгчид “нийгмийг өөрчлөх шинэ филантропийг хөгжүүлэх”-ийг эрмэлзэж байна.

“Хүмүүс хамтарч чадвал алхам алхамаар нийгэмд шинэ өөрчлөлтийг авчрах учраас нинжин сэтгэлийн өглөг, хандивыг нийгмийн төлөө үйл ажиллагаа явуулж байгаа ашигийн бус байгууллагуудад өгөх хэрэгтэй” гэж үзэх болсон.

Ашгийн бус байгууллагууд нь нийгэмд байгаа бэрхшээлтэй олон асуудлыг шийдвэрлэхийг эрмэлзэж шинэ санааг хэрэгжүүлдэг. Эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг хөгжүүлэх, тогтвортой ажиллагааг хангахад санхүүгийн дэмжлэг үзүүлж туслах явдал юунаас ч чухал. Өв залгамжилсан хувийн сангаас гадна олон нийтийн сан хөрөнгө хуримтлуулан ялангуяа бүлэг хүмүүсийн үйл ажиллагаанд зохистой хуваарилдаг нь нийгэмд байгаа бэрхшээлтэй асуудлыг иргэд өөрсдөө шийдвэрлэх, цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэх, үр дүнг тооцох олон давуу талтай. Олон нийтийн сангууд хөрөнгө хуримтлуулахдаа:

1. Хувийн сангуудаас санхүүжилт олох
2. Хувь хүмүүс болон байгууллагуудаас хандив цуглуулах
3. Үйл ажиллагаа явуулж орлого олох олон аргыг хэрэглэдэг.

Хөгжсөн орнуудад хүмүүс мөнгөө олон төрлийн хөтөлбөр хэрэгжүүлдэг төлөвлөгөөтэй, ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллагын үйл ажиллагаанд өгөхийг эрмэлздэг байна. Тэд нэг тодорхой төслийг хэрэгжүүлэхэд хандив өргөхийг илүүд үздэг.

Гуравдугаар бүлэг

Өгье гэвэл өнчин ишигнээс хот дүүрнэ



МОНГОЛЧУУДЫН ФИЛАНТРОПИ СЭТГЭЛГЭЭ

Монголчуудын хувьд бие биедээ туслах уламжлалт харилцаа их онцлогтой байжээ. Эдүгээ хэн ч гэсэн тусламж дэмжлэг үзүүлсэнийхээ болон үйлчилснийхээ хариуг “мөнгө” эсвэл таваараар тооцдог бол манайд тийм дүрэм журам байсангүй. Нүүдлийн соёл иргэншилтэй монголчуудын хувьд “харилцан туслалцах” хэмээх чухал ойлголтыг дан ганц ураг төрлийн хэлхээтэй холбон үзэж байсангүй. Энэ нь таньдаг, таньдаггүй, хар элгийн хүмүүсийн хоорон дахь харилцаанд ч мөрдлөг болж байв.

Монголчуудын “харилцан туслалцах” хэрэгцээ нь:

1. Ган зуд, салхи, шуурга, үер ус гэх мэт байгал цаг уурын хүнд бэрхшээлийг даван туулах,
2. Хүн ам цөөн тул хамтаар бүлдэж аж амьдралаа зохион байгуулах, /нүүдэллэх,

хашаа хороо барих, хадлан өвс авах, мал хуйгаа хариулах гэх мэт/

3. Хүний амьдрах, оршихуйн анхдагч хэрэгцээ болсон эв эеийг хичээх, энх амгалан аж төрөх, үндэсний ёс заншил, түүх, соёл өв уламжлалаа хадгалж, улс төр, тусгаар тогтнолоо хамгаалах хүсэл эрмэлзэл дээр илэрч энэ нь ямар ч хууль дүрэмгүйгээр мөрдөгддөг.

Мөн айл саахалтынхаа дээрх зорилгоор тодорхой цаг хугацаа зарцуулан зүтгэсний хөлс хариуг шууд “тооцдоггүй” онцлогтой. Ажил үйлст нь туслалцаа дэмжлэг үзүүлсэн хүнд өөрт нь мөн тийм шаардлага гарах үед айл хөршийнхөн нь эргэж тус хүргэдэг бичигдээгүй хууль үйлчилж байсан гэж үзэх бүрэн үндэстэй. Ийм учраас монголчуудын “аяганы хариу өдөртөө, агтны хариу жилдээ” гэж ярьдаг нь энэ утга санааны илэрхийлэл гэж үзэж болно.

Монголчуудын бие биедээ үзүүлэх тусламж дэмжлэг нь магадгүй тэдний ажил хөдөлмөрийн амьдрал үйл ажиллагааны нь гол түлхэц хүчин зүйл болж ирсэн онцгой ач холбогдол бүхий харилцааны өндөр соёл байсан хэмээн үзэж болох юм. Үүнээс гадна зарим үйл ажиллагаа нь ардын ёс заншил болоод уламжлагдан үлдсэн байдаг. Жишээ нь, хол-нүүдэл хийж яваа айлыг танихгүй ч байсан тавагтай идээ, данхтай цайгаа барьсаар угтаж хөдөө хээр цайлуулаад сайн явж нүүдэллэхийг ерөөгөөд үддэг ёс өөр аль ч улс оронд байхгүй билээ.

Монголчууд олон зуун жилийн турш “хүнд тус хийвэл өөрт тус ирнэ”, “сайн санааны үзүүрт тос”, “буян үйлдвэл сайн явна” хэмээн үзэл санаа, оюуны бүтээлээрээ хоёр, гурван мер зүйр цэцэн үгэнд шастирлаж үр хүүхдийнхээ

ой тогтоомжид гүн бат тогтоолгон
амьдралд нь хэвшүүлдэг байсан сурган
хүмүүжүүлэх арвин туршлагатай, шилдэг
өв уламжлалтай ард түмэн билээ.
Нэрт эрдэмтэн бичгийн их хүн Дандаа
Чинсан хэмээх Ч. Дэмчигдорж: Ядуу
дордос, өнчид, бэлбэсэн эхнэр, өвчтэй
хүн, өтгөс өвгөд, хол нутгийн буюу
гэнэдэж эндсэн хүнд тусалсан сайн
санаатныг “Богд хүн” хэмээн өргөмжлөн
эрдэнийн сан шастиртаа тэмдэглэжээ.

Дөрөвдүгээр бүлэг

*Нэг хүний тус нөгөө хүний амьдралыг
өөрчлөх агуу их шидтэй ажгуу.*



ТА ФИЛАНТРОПЧ

Нэг. Филантропчид ямар учраас хандив өргөдөг вэ?

Хүн бүр аливаа үйл ажиллагаанд хүч нэгтгэн оролцохдоо өөр өөрийн хүсэл эрмэлзэл, итгэл үнэмшлийг агуулдаг билээ. Тэгвэл энэрэн нигүүлсэх, филантропи үйл ажиллагааны нэгээхэн чухал хэсэг болох өөрийн хөрөнгө мөнгөнөөсөө хандив өргөн дэмжлэг туслалцаа үзүүлэхдээ дараах хүсэл эрмэлзэл, зорилго, зорилтыг агуулсан байдаг байна. Үүнд:

- өгөөмөр сэтгэлийн үүднээс,
- хүндэтгэж, итгэж явдаг хэн нэгнээ дэмжихийн тулд,
- итгэл хүндэтгэл үзүүлдэг байгууллагынхаа зорилгыг хэрэгжүүлэхэд туслахын тулд,
- бусад хандивлагчид болон ашгийн бус салбарт тэргүүлэгчидтэй хамтран ажиллахын тулд,
- байгууллагынхаа санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэхийн тулд,

- олон нийтийн нөлөөллийн бодлогын уялдаа холбоог бататгахын тулд,
- баримтжуулах, судалгааны ажил явуулахын тулд,
- тодорхой бүлгүүд хамтран ажиллаж сурахын тулд,
- олон нийтийн боловсролын асуудалд хувь нэмрээ оруулахын тулд,
- уламжлал, соёлыг хөгжүүлэхийн тулд,
- зарим бүлгүүдийн статусыг дээшлүүлэхийн тулд,
- хүний эрхийг хангаж, хамгаалахын тулд гэх мэт олон хүсэл эрмэлзэл, итгэл үнэмшлийг агуулдаг болох нь тодорхой байна.

Хоёр. Филантропч болохын ач холбогдол

Энэ нь 6 түвшингээр ангилагддаг.

Нэгдүгээр түвшин: Хандивлагч болох

Олон төрлийн хүчин зүйлээс шалтгаалж хувь хүн хандивлагч болдог. Ядуусын амьдрал, амьдралын баталгаа, боловсрол, чадвар, хүний эрх гээд санаа зовоосон зүйлүүд их байдаг. Үүнийг өөрчлөхийн төлөө өгөөмөр сэтгэл гаргах нь хүн бүрийн үүрэг гэж үзэж хандив өгч эхэлдэг. Энэ нь яваандаа нийгмийг өөрчлөх хүсэл мөрөөдөл болж хувирдаг. Гэвч энэ түвшинд тухайн хүний хандивлаж байгаа хандивын хэмжээ бага байдаг.

Хоёрдугаар түвшин:

Зохион байгуулалттай болох

Энэ үед хандивлагч өгч байгаа хандивтаа дүн шинжилгээ хийж эхэлдэг. Хаана өгсөн хандив тухайн хүнийг сэтгэл хангалуун болгосоноо олж дүгнэдэг. Иймээс ямар шалгуураар, ямар үйл ажиллагаанд хандив өргөх өөрийн гэсэн үнэлэмжийг бий болгож

эхэлдэг. Цөөн боловч томоохон хэмжээний хандив өргөдөг болно.

Гуравдугаар түвшин:

Илүү төлөвлөж хандив өргөх

Ямар салбар, ямар асуудал байгааг илүү сонирхож судлах, хүмүүстэй санал солилцох, бэрхшээлтэй хүмүүстэй уулзах, холбогдох материалыг олж унших, энэ чиглэлээр ажиллаж байгаа байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах зэрэг ажлуудыг хийдэг. Энэ түвшинд хандиваа тодорхой салбар, тодорхой асуудалд чиглүүлэн өргөх ёстой гэсэн чиглэлтэй болсон байна.

Дөрөвдүгээр түвшин: Асуудал болон үр дүнд анхаардаг болно.

Энэ түвшинд хандивлагч өгсөн хандивынхаа үр дүн, үнэлгээнд илүү

анхаардаг болно. Тэгээд хандивын хэмжээгээ нэмэгдүүлэх нь өөрчлөлт хийх боломжийг нэмэгдүүлнэ гэдгийг ойлгож эхэлнэ. Хандивлагч хөгжихийн хирээр үр бүтээлтэй ажиллаж чадах сайн хүмүүс, байгууллагыг эрж хайж эхэлдэг. Тэгснээр хандивлагч маань илүү мэргэжлийн түвшинд хүрсэн филантропич болдог.

Тавдугаар түвшин: Зорьсондоо хүрэх нь Энэ түвшинд хандивлагчийн өргөсөн хандив, хөрөнгө мөнгө нь урт хугацаатай үйл ажиллагааны хөтөлбөрийг санхүүжүүлэхэд чиглэгддэг. Хандивлагч санхүүжүүлж байгаа байгууллагынхаа үйл ажиллагааны талаар харьцангуй өндөр мэдлэгтэй болсон байх ба ямар үйл ажиллагаа хүний болоод нийгмийн хөгжилд өөрчлөлтийг бий болгодгийг мэддэг болсон байна.

Зургадугаар түвшин:

Уялдаа холбоо ба зохицолдлого

Хандивлагч хүн өөрийнхөө дотоод ертөнцөд нуугдан байгаа бусдыг хайрлах, энэрэх мэдрэмж, хандив өргөх хүсэл сонирхолоо тэнцүүлж чаддаг болно. Эцэст нь хувь хүний үзэл баримтлал нь бүхий л амьдралынх нь хамгийн нандин бахархал төрүүлэх дурсамж үлдээсэн сэтгэл хангалуун үйл явдалуудын нэг болно.

Гурав. Жинхэнэ филантропч

- Жилд өргөх хандив, үзүүлэх санхүүгийн дэмжлэгээ төсөвлөж төлөвлөдөг.
- Энэхүү хандивыг өргөснөөр гарах үр дүн ямар байх талаар тодорхой төсөөлөлтэй байдаг.
- Харилцагч болох нийгмийн төлөө ажиллаж байгаа байгууллагын удирдагч,
- Төлөөлөгч гишүүдтэй гэртээ хүлээн авч уулзах цаг гаргадаг.

- Хандив өргөх, хөрөнгө оруулах, сайн дурын үйл ажиллагаанд оролцох цагаа зохицуулж чаддаг.
- Ашгийн бус байгууллагын үйл ажиллагаанд зориулж гаргах хандиваа жил бүр төлөвлөдөг.
- Хандивлагчийн хувьд доод тал нь 3 жил үргэлжлүүлэн хандив өргөдөг.
- Бусдыг филантропи үйл хэрэгт уриалан дуудаж хандивлагч болгодог.
- Ядуурал буюу аль нэг асуудлын шалтгаан үр дагварыг арилгахын аргыг эрж хайн тэдгээрийг тогтвортой өөрчлөхийн төлөө ажилладаг.
- Уян хатан шийдвэр гаргадаг.
- Аливаа хүсэлт гуйлтанд заавал хариу өгдөг.
- Хүмүүсийн цагийг үнэлдэг.
- Хандив гуйхыг хүлээлгүй өөрөө сайн дураар хандив өргөдөг.
- Тухайн байгууллагатай хамтын

ажиллагаагаа хэрхэн яаж төгсгөхөө мэдэрдэг.

- Шинээр холбоо тогтоох боломжийг нээлттэй байлгадаг.

Дөрөв. Хүүхэд, залуучуудад бусдын төлөө гэх сэтгэлийг төрүүлж хандив өргүүлж сургах нь

Хүүхэд, залуучууд өөрсдийн хүслээр ямар ч байдлаар филантропи үйл ажиллагаа явуулж болно.

Жишээлбэл,

1. Өсч том болсны баяр тэмдэглэж төрсөн өдрөөр авсан бэлэг, мөнгөний тодорхой хувийг нийгмийн эмзэг бүлгээс гаралтай хүүхдүүдэд, эсвэл өөрийн сонирхол татсан ашгийн бус нэгэн салбарт хандивлаж эхэлснээр зарим хүүхдүүд филантропи үйл ажиллагаанд оролцож болох юм.
2. Шинэ жил, хүүхдийн баяраар тодорхой

хэмжээний мөнгө хуримтлуулж тусламж дэмжлэг шаардлагатай байгаа хүмүүс, байгууллагад хандивлах нь филантропи үйл ажиллагааны бас нэг хэлбэр байж болох юм. Энэ нь өгч байгаа болон авч байгаа хүүхдүүдийн сэтгэл санаанд баяр баясгаланг төрүүлдэг.

Тав. Хандивлагчийн эрх —

1. Хандив өргөх байгууллагын зорилго, хандивын мөнгийг хэрхэн зарцуулах тухай мэдээлэл,
2. Тухайн байгууллагын удирдах зөвлөлд ямар ямар хүмүүс байдаг. Шийдвэрээ хэрхэн гаргадаг талаар мэдээлэл авах,
3. Сүүлийн санхүүгийн тайлантай танилцах,
4. Өргөсөн хандиваа зориулалтын дагуу зарцуулахыг баталгаажуулахыг хүсэх,
5. Хандивыг хүлээн авсан баталгаа, таниулга хүлээн авах,
6. Хандив хүсч байгаа хүн байгууллагын

ямар албан тушаалтан болохыг мэдэх,
шалгах,

7. Байгууллагын аливаа нэгэн мэдээлэлийн
санд нэрээ оруулахыг хүсэхгүй байх,

8. Хандив хүсч ирсэн тохиолдолд
холбогдох асуултыг чөлөөтэй асууж шууд,
үнэн зөв хариулт авах зэрэг болно.

Тавдугаар бүлэг

*Та бидэнд тусла, бид нийгмийг
өөрчлөхөд хувь нэмэр оруулья.*



**МОНГОЛЫН
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН
САН ФИЛАНТРОПИ
БАЙГУУЛЛАГА**

Монголын Эмэгтэйчүүдийн Сан /МОНЭС/
2000 онд байгуулагдсан ба хөрөнгө нөөцийг
хуримтлуулж эмэгтэйчүүдийн эрх, хөгжилийн
төлөө ажиллаж байгаа эмэгтэйчүүд
удирдсан бүлгүүдэд санхүүгийн дэмжлэг
үзүүлдэг олон нийтийн сан юм.

МОНЭС гадаад, дотоодын байгууллагуудаас
хөрөнгө нөөцийг хуримтлуулахаас гадна
дотооддоо 3000 гаруй хувь хүмүүсээс
хандив цуглуулсан нь нэг талаар нийгмийн
хөгжлийн төлөө хандив өргөдөг филантропи
сэтгэлгээг олон нийтэд ойлгуулан таниулах,
нөгөө талаар хуримтлуулсан мөнгийг хувь
хүн болоод бүлэг хүмүүсийн хөгжилд үр
дүнтэй өөрчлөлт авчирахуйц төслүүдэд
үр ашигтай зарцуулахын төлөө ажиллаж
байгаа филантропи байгуулага юм.

Үүний тулд дараахь дөрвөн чиглэлээр
Эмэгтэйчүүдийн төрийн бус байгуулага
/ЭТББ/ болон бүлгүүдэд санхүүжилт олгодог.

Үүнд:

- Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт ба хүчирхийлэл
- Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлж, орлого нэмэгдүүлэх
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, оролцоог дэмжих
- Эмэгтэйчүүдийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх гэсэн чиглэлүүд багтдаг.

Өнгөрсөн хугацаанд 125 төсөлд зориулж 310 сая төгрөгийг ЭТББ, бүлгүүдэд санхүүгийн тэтгэлэг болгон олгоод байна.

Та бүхэнд дотоодын байгууллага, хувь хүмүүсээс цуглуулсан хандиваар ямар үр дүнтэй ажил явуулсныг зарим нэг жишээгээр танилцуулья.

• Эмэгтэйчүүдийн хүний эрхийн чиглэлээр:

Ажлын байран дахь бэлгийн дарамтлал

/АББД/-тай тэмцэх асуудал МОНЭС-ийн анхаарлын төвд байдаг. 88 өдрийн хөрөнгө цуглуулах кампанит ажил зохион байгуулж 10,7 сая төгрөг хуримтлуулж Эмэгтэйчүүдийн 4 байгууллагад санхүүжилт болгон олгосны үр дүнд:

- Хөдөлмөр эрхлэхтэй холбоотой 10 гаруй хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулагдан гарлаа.
- Сургагч багш болон хууль боловсруулагч нарт зориулсан гарын авлага гарлаа.
- Хот хөдөөгийн сэтгүүлчдэд АББД-тай холбоотой асуудлыг олон нийтэд хэрхэн ойлгуулах вэ гэсэн сургалт явагдлаа.
- Хууль боловсруулагч, хэрэгжүүлэгч төрийн байгууллагууд болон ТББ-ын ажилтануудад зориулсан сургалт, хэлэлцүүлэгүүд зохион байгуулагдаж сургагч багшийн болон ТББ-дын эвсэл, сүлжээнүүд байгуулагдан олон нийтийг гэгээрүүлэх, бодлого болон хуулийг хэрэгжүүлэхэд нөлөөлөхөөр ажиллаж байна. Үүний эхний үр дүнд Ерөнхий боловсролын болон Их дээд сургуулийн багш нарын

ёс зүйн дүрэмд “ажлын байранд бэлгийн дарамтлал үйлдэхийг хориглоно” гэсэн заалт орсон.

• Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлж, орлого нэмэгдүүлэх чиглэлээр:

МОНЭС хөгжлийн бэрхшээлтэй охидын эрхийг хамгаалах, тэдний амьдрах чадварыг дэмжихийн тулд 2 сая төгрөг хуримтлуулсаныг 2 байгууллагад олгож жижиг гар урлалын зүйл хийх, зураг зурах, фото зураг авах авьяасыг хөгжүүлэх сургалтанд зориулсан. Нийтдээ 30 орчим охид энэ сургалтанд хамрагдаж авьяас чадвараа нэмэгдүүлэх, өөрийгөө хөгжүүлэх боломжтой болсон.

Мөн архинд гүн хордсон эмэгтэйчүүдийг нийгэмшүүлэх, тэднийг орлого олох өрсдийн амьдралдаа өөрчлөлт хийх чадвартай олгохын тулд хөрөнгө мөнгө хуримтлуулж

ёс зүйн дүрэмд “ажлын байранд бэлгийн дарамтлал үйлдэхийг хориглоно” гэсэн заалт орсон.

• Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлж, орлого нэмэгдүүлэх чиглэлээр:

МОНЭС хөгжлийн бэрхшээлтэй охидын эрхийг хамгаалах, тэдний амьдрах чадварыг дэмжихийн тулд 2 сая төгрөг хуримтлуулсаныг 2 байгууллагад олгож жижиг гар урлалын зүйл хийх, зураг зурах, фото зураг авах авьяасыг хөгжүүлэх сургалтанд зориулсан. Нийтдээ 30 орчим охид энэ сургалтанд хамрагдаж авьяас чадвараа нэмэгдүүлэх, өөрийгөө хөгжүүлэх боломжтой болсон.

Мөн архинд гүн хордсон эмэгтэйчүүдийг нийгэмшүүлэх, тэднийг орлого олох өрсдийн амьдралдаа өөрчлөлт хийх чадвартай олгохын тулд хөрөнгө мөнгө хуримтлуулж

2 удаагийн төслийг санхүүжүүлсэн. Үүний үр дүнд 20 эмэгтэй хорт зуршлаасаа гарч жижиг гар урлалын зүйл хийж сурсан ба хийсэн бүтээгдэхүүнээ зарж болруулан өдөр тутам бага боловч орлоготой болж чадсанаас гадна гэр бүлийн бусад хүмүүст ч эерэг өөрчлөлт гарсан юм.

МОНЭС жил бүхэн Олон улсын Филантропи өдрийг тэмдэглэх кампанит ажлыг зохион байгуулж хандив цуглуулдаг ба мөн ТББ-дад санхүүгийн тэтгэлэг олгодог.

Энэ жил хүнд нөхцөлд амьдарч байгаа олон хүүхэдтэй ээжүүдийн амьдралд өөрчлөлт гаргахын тулд хандив цуглуулахаас гадна 5 бүлэгт санхүүгийн тэтгэлэг олгоно.

Бидний үйл хэргийг дэмжиж Та ч гэсэн халуун сэтгэлийн гараа сунгаж хандив өргөн дэлхий дээрх сая сая хандивлагчдын нэг болж болох бөгөөд “огт хоцроогүй” гэж танд хэлмээр байна. Яагаад гэвэл МОНЭС-д хэдийд ч хандив өргөж болох ба манай

хаягаар харилцахад л таны үүд хаалга нээгдэнэ. Таны өөрийн боломжийн хирээр өргөсөн хандивийг тань бид нийгмийг өөрчлөхөд оруулсан үнэлж баршгүй хувь нэмэр гэж үзэх болно.

“Би хүнд бэлэг өгөх дуртай. Яагаад гэвэл тэдний баярласан царайг хараад би ч бас баярладаг” гэж энэ зууны алдарт бизнесмен Доналд Трампын хэлсэн үгээр энэхүү номоо дуусгая.

Анхааран уншсан Танд баярлалаа.



Монголын Эмэгтэйчүүдийн Сан /МОНЭС/

Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг
6 дугаар хороо, 44 дүгээр байр, 4 тоот
Утас/факс: 976-11-317904
E-мэйл: mones@mongol.net
Web: www.mones.org.mn



Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг
6 дугаар хороо, 44 дүгээр байр, 4 тоот
Утас/факс: 976-11-317904
E-мэйл: mones@mongol.net
Web: www.mones.org.mn



Монголын Эмэгтэйчүүдийн Сан /МОНЭС/